



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.03.22 № 02-01-001/59
танай _____ -ны № _____ -т

9
ДҮҮРГИЙН СОЁЛЫН ОРДОНД

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийхээр зарлагдсан түүх, соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын байдалд Төрийн хяналт шалгалтын тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих бөгөөд үйл ажиллагаандаа дараах зөвлөмжийг анхаарч ажиллана уу.

Нэг. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.6 дах хэсэгт заасны дагуу биет өвийн мэдээллийн санг бүрдүүлсэн байх;
- 1.2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгал түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 1.3. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.6 дах хэсэгт заасны дагуу үл хөдлөх дурсгалт зүйлд хууль бус малтлага хийгдээгүй байх;
- 1.4. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.5 дах хэсэгт заасны дагуу соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, бүртгэл мэдээллийн санд мэдэгдсэн байх;
- 1.5. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дах хэсэгт заасны дагуу хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж, хамгаалалтын бүс тогтоосноос бусад үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтад иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хяналт тавьдаг байх;
- 1.6. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дах хэсэгт заасны дагуу сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталж, хамгаалалтын дэглэм тогтоож, хяналт тавьдаг байх;
- 1.7. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх хэсэгт заасны дагуу хамгаалалтын бүсэд аюул учруулахаар үйл ажиллагаа явуулаагүй байх;
- 1.8. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дах хэсэгт заасны дагуу хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж

001120503759


ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, палеонтологи, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх;

- 1.9. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.10, 15.1.6, 53.1 дэх хэсэгт заасны дагуу соёлын өв устгах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа тохиолдолд авран хамгаалах, сэргээн засварлах талаар дээд шатны байгууллагад мэдэгдэх, холбогдох арга хэмжээ авах;
- 1.10. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасны дагуу биет өвийг сэргээн засварлахдаа анхны төрх, хийцийг хадгалан, аюулгүй байдалд удаан хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх;

Хоёр. Дээрх зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллаагүй тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 60 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хариуцлага хүлээхийг анхаарна уу.

Зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч, дотоод хяналтаа сайжруулж ажиллахыг ЗӨВЛӨЖ байна.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСРОЛ СОЁЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Д.ЦЭНД-АЮУШ

СОЁЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Ч.ДАРИЙМАА